

ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТСИЙН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Ө.НАМУУНБАЙГАЛЫН 2024 ОНЫ ЭХНИЙ
ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн дууссан хугацаа
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		
	1	2	3	4	5	6	
Зорилт 1. Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах							
1	Олон улсад гаалийн чиглэлээр хэрэглэж буй баримт бичгийг судалж, боловсруулсан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Бодлогын баримт бичиг болон үндэсний хөтөлбөр, хууль тогтоомжид тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулан, хяналт тавьж, биелэлтийг нэгтгэн гаргаж, хугацаанд нь тайлагнана.	Дэлхийн гаалийн байгууллагын Тариф, Худалдааны Газраас 2024 оны 03 дугаар сарын 25-29-ны өдрүүдэд Гаалийн ерөнхий газарт зохион байгуулагдсан “Гарал үүслийн үндэсний семинар”-т ашиглагдсан сургалтын гарын авлагуудыг орчуулж, албан хаагчдыг мэдээллээр хангасан. Үүнд: - Барааны ангилал, Барааны гарал үүслийг тодорхойлох практик, дасгал ажлын материал - Олон улсын худалдааны гарал үүслийн дүрэм, Гаалийн байгууллагын үүрэг, ерөнхий хүчин зүйлс илтгэл - Гарал үүслийн нийтлэг алдаа ба зөрчил илтгэл Гарал үүслийн дүрмийн талаарх ДГБ-ын үйл ажиллагаа илтгэл гэх мэт сургалтын гарын авлагуудыг Монгол хэл рүү албан хэрэгцээнд зориулан орчуулж, албан хаагчдыг мэдээллээр хангаж, чадавхижуулах чиглэлд ажилласан байна.	01.01-06.05	
2	Хамтын ажиллагааны арга хэмжээг зохион байгуулсан байдал, гэрээ, хэлцэл, төсөл хөтөлбөрийн хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Гадаад худалдааны статистик зэрэгцүүлэлтийн чиглэлээр хамтын ажиллагааг үнэлж, дүгнэн, цаашдын чиглэлийг тодорхойлсон байна.	ОХУ-ын ХГА-тай цаг үеийн болон тулгамдсан асуудлаар 60 гаруй цахим захидал, 38 албан бичиг солилцож, хоёр орны гадаад худалдааны статистик мэдээлэл, түр хугацаагаар оруулсан 240+ зорчигчийн хувийн автотээврийн хэрэгслийн талаарх мэдээлэл солилцон хамтын ажиллагааг хөгжүүлэн ажилласан. ОХУ-ын ХГА-ны Эрсдэлийн удирдлагын хүрээнд хамтран ажиллах хэлэлцээрийн хүрээнд шинжээчдийн анхдугаар уулзалтыг амжилттай зохион байгуулж цаашдын хамтын ажиллагааны төлөвлөгөөний төслийг тохиролцсон. ОХУ-тай хийсэн 2023,2024 оны гадаад худалдааны статистик мэдээллийг түнш орны статистикийн мэдээлэлд зэрэгцүүлэлт хийх зорилгоор ОХУ-ын ХГА-тай албан бичгээр солилцсон. Монгол, Оросын ЗГХК-ын 25 дугаар хуралдаан болон Монгол, Хятадын ЗГХК-ын 17 дугаар хуралдааны протоколуудыг хэрэгжилтийг эрчимжүүлэх	01.01-06.05	

					зорилгоор Гадаад харилцааны яамны Хөрш орнуудын газраас зохион байгуулсан уулзалтад оролцож тулгамдаж буй асуудлаар санал солилцсон. Гадаад худалдааны эдийн засгийн үйл ажиллагаанд оролцогч хоёр орны ААН-үүдийн барааны экспорт болон импортын гаалийн мэдүүлэг, дагалдах бичиг баримтын хуулбарыг хоёр талын холбогдох нэгжүүдийн хүсэлтээр солилцсон (800 хуудас орчим).	
Зорилт 4. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”						
1	Албан хаагчдыг гадаад болон гадаадын экспертүүдийн сургалтад хамруулсан байдал, үр дүнг тооцох ажлыг зохион байгуулсан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэл эр	-	Албан хаагчдыг гадаадад болон гадаадын экспертүүдийн сургалтад хамруулах, сургалтын үр дүн гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжиж үр дүнгээ өгөх. Үүнд: Гадаад хамтын ажиллагааны хүрээнд хоёр талт болон олон талт 15 уулзалт; - Олон талт болон хоёр талт хамтын ажиллагааны хүрээнд 5 сургалт зохион байгуулах	ДГБ, ОУВС, НҮБ, КАРЕК, АНУ, БНСУ, БНХАУ, ОХУ болон бусад орны гаалийн байгууллага төсөл хөтөлбөртэй хамтран цахим болон биет хэлбэрээр нийт 23 (гадаад 11; монголд: 10; Үндэсний: 2) арга хэмжээг зохион байгуулж 120 албан хаагч хамруулсанаас ГЕГ-аас 90 (75%); ГГХ 30 албан хаагч (25%) байсанаас 55 албан хаагч биет хэлбэрээр гадаад улсад арга хэмжээнд оролцсон байна. Дээрх сургалт, уулзалтын чиглэлийг хувиар үзвэл: 29.6 хувийг “Мэргэшлийн мэдлэгээ дээшлүүлэх”, 28.3 хувийг “Эдийн засгийн өрсөлдөх чадварыг бэхжүүлэх”, 21.4 хувийг “Хууль сахиулах”, 20,7 хувийг “Худалдааг хөнгөвчлөх” чиглэл тус тус эзэлж байна. Үүнд: Гадаадад болон Монголд зохион байгуулсан гадаад арга хэмжээ: 43 · Уулзалт, хурал (11): Нийт 55 албан хаагч оролцсоноос ГЕГ-аас 50 албан хаагч, ГГХ-оос 5 албан хаагч; · Сургалт (12): Нийт 65 албан хаагч оролцсоноос ГЕГ-аас 40; ГГХ 25 албан хаагч; ДГБ-ын Зөвлөлийн хуралдаан, Хороодын уулзалт, Ази, Номхон Далайн бүс нутгийн Дарга, Холбоо баригч нарын төлөвлөсөн уулзалтуудын төсвийг урдчилан тооцож жилийн эхэнд батлуулсан ба Монгол Улсын Гаалийн байгууллагын идэвх, оролцоог шинэ шатанд гаргах зорилгоор төлөвлөгдөөгүй зарим хурал, уулзалтад оролцох зардлын төсөвийг ГЕГ-ын даргаар батлуулж ажиллаж байна. ДГБ-ын чуулган энэ жилийн УИХ-ын сонгуультай давхцаж байгаа тул цахимаар оролцохоор шийдвэрлэгдсэн.	01.01-06.05
2	Монголын гаалийн байгууллагын үйл ажиллагааг гадаад орнуудад сурталчилах, холбоо баригчийн үүрэг гүйцэтгэх ажлыг зохион	Хэрэгжилт, гүйцэтгэл эр	-	Монголын гаалийн байгууллагын үйл ажиллагааг гадаад орнуудад сурталчилж, гаалийн асуудлаар холбоо баригчийн үүрэг гүйцэтгэн ажиллана.	АНУ, БНСУ, БНХАУ, ОХУ, Узбекистан Улсын болон бусад орны гаалийн байгууллагатай холбоо баригчийн үүрэг гүйцэтгэх ажлыг зохион байгуулж албан захидалаар болон цахим шуудангаар мэдээлэл солилцон ажилласан. Үүний үр дүнд дээрх орнуудтай байгуулсан хэлэлцээр, журам бичиг баримтын хэрэгжилтийг хангасан. Түүнчлэн Узбекистантай байгуулах “Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай Бүгд Найрамдах Узбекистан Улсын Засгийн Газар болон Монгол Улсын Засгийн Газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн төслийг тохиролцсон. “Олон улсын гаалийн өдөр 2024” өдөрлөгийг цахим хэлбэрээр амжилттай тэмдэглэн өнгөрүүлсэн. ДГБ-ын бодлого, чиглэл, хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, зургийн уралдаан зэрэг 10 чиглэлээр цахим гарын авлага, видео, постер, брошур олон нийт, гаалийн байгууллагын хамт олон, цахим, цаас,	01.01-06.05

	байгуулсан байдал				урсдаг самбар, олон нийтийн хуудсаар түгээсэн нь гаалийн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчилж ажилласан.	
3	Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гадаад бичиг баримт орчуулж, гадаад хурал, арга хэмжээнд албан ёсны орчуулга хийх ажлыг зохион байгуулсан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэл эр	-	Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гадаад бичиг баримт орчуулж, гадаад хурал, арга хэмжээнд албан ёсны орчуулга хийх ажлыг зохион байгуулж, орчуулгын талаар оновчтой тайлагнах.	Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гадаад бичиг Баримтыг орчуулж, 3 арга хэмжээнд албан ёсны орчуулга хийсэн. Томоохон арга хэмжээнээс дурдвал: - Узбекистантай байгуулах "Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай Бүгд Найрамдах Узбекистан Улсын Засгийн Газар болон Монгол Улсын Засгийн Газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг"-ийн төсөлд ирүүлсэн ГЕГ-ын бүтцийн нэгжүүдээс ирүүлсэн саналуудыг төсөлд тусгаж, орчуулан Узбекистаны тал руу хүргүүлсэн. - Улаанбаатар хотноо 5-р сарын 29-ний өдөр болох ИТС-ын Гаалийн дэд хорооны 6-р уулзалт дээр тавих ГЕГ-ын Хяналт, бүрдүүлэлтийн хэлтсийн 2 презентацыг орчуулан нэгтгэн, бэлдэв. - "Гаалийн зөрчилтэй тэмцэх" асуудлаар 2024 оны 6-р сарын 10-ны өдөр Улаанбаатар хотноо болох Монгол Улсын ГЕГ, Сибирийн болон Алс Дорнодын гаалийн албад хоорондын 7-р уулзалтад оролцож, протокол хөтөлж, бэлтгэл ажлын хэлэлцэх асуудал танилцуулга зэргийг орчуулж бэлдэв. - Хяналт, бүрдүүлэлтийн газрын ГУАБ Б.Болормаагийн НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх албаны Чингэлгийн хяналтын хөтөлбөрийн хүрээнд 2024 оны 4-р сарын 11-ний өдөр ГЕГ дээр болох уулзалтын үеэр тавих мэдээллийн англи орчуулгыг хянав. - ОХУ-ын ХГА-ны Итгэмжлэгдсэн ААН-ийн асуудалаарх 3 дугаар сарын 12-ны цахим уулзалт болон Эрдсдэлийн удирдалгын Хэлэлцээрийн хүрээнд 2024.06.10-12-ны хооронд хийсэн шинжээчдийн уулзалтаар албан ёсны орчуулга хийсэн. - ОХУ-ын ХГА-ны 2011 оны 4-р сарын 22-ны өдрийн 845 тоот тушаалаар батлагдсан "Мэдүүлж буй газраас хол орших гаалийн байгууллагын харъяалах бүс нутагт байгаа барааг цахимаар мэдүүлэх тохиолдолд мөрдөх гаалийн үйл ажиллагааны журам"-ыг орчуулсан.	01.01-06.05
4	ДГБ бусад олон улсын байгууллагатай хамран ажиллаж, гаалийн байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд олон улсын тэргүүн	Хэрэгжилт, гүйцэтгэл эр	-	ДГБ болон бусад олон улсын байгууллагатай (ДГБ, НҮБ, ОУВС, Их түмэн санаачилга, КАРЕК гэх мэт) хамтран ажиллаж, гаалийн байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд олон	ДГБ болон бусад олон улсын байгууллагатай (ДГБ, НҮБ, ОУВС, Их түмэн санаачилга, КАРЕК гэх мэт) хамтран ажиллаж, цахим болон биет хэлбэрээр нийт 23 арга хэмжээг зохион байгуулж 120 албан хаагч хамруулж гаалийн албан хаагчдын чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг болсон. Түүнчлэн ДГБ-аас зарласан Бүс нутгийн гаалийн байгууллагуудын Лабораторын ажилтныг чадавхижуулах тэтгэлэгт хөтөлбөр, Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА), ДГБ-аас зарласан Оюуны өмч, Стратегийн менежментийн чиглэлээрх Магистрын 1 жилийн хөтөлбөрийн мэдээлэл, GTI-ийн Барааг дотоод болон гадаадад боловсруулалт хийх журмын ажлын хэсгийн мэдээлэл зэргийг бэлдэж	01.01-06.05

	туршлага, арга хэрэгслийг судалж санал, зөвлөмж боловсруулах, үйл ажилаагаан даа нэвтрүүлэх ажлыг зохион байгуулсан байдал			улсын тэргүүн туршлага, арга хэрэгслийг судалж санал, зөвлөмж боловсруулах, үйл ажилаагаандаа нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.	захиргаа дотоод хэргийн Спарк системээр түгээсэн. Үүний үр дүнд 3 албан хаагч нэр дэвшээд байна. олон улсын тэргүүн туршлага, арга хэрэгслийг судалж санал, зөвлөмж боловсруулах, үйл ажилаагаанд дэмжлэг болох зорилгоор Монгол Улсын гаалийн байгууллагаас санаачилсан ИААН-ийн хөтөлбөрийн төслийг 5-р сарын 29-ний өдөр Улаанбаатар хотноо болсон ИТС-ын Гаалийн дэд хорооны 6-р уулзалт дээр болон 5-р сарын 30-ны өдөр мөн Улаанбаатар хотноо болсон ИТС-ын Худалдаа, хөрөнгө оруулалтын хорооны 6-р уулзалт дээр тус тус танилцуулав.	
					- Монгол-Солонгосын хооронд Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах хэлэлцээний Улаанбаатар хотноо болох 2-р раундын бэлтгэл ажлын хүрээнд ГЕГ-аас оролцож буй багт зөвлөгөө өгөв. - Олон улсын валютын сангаас "Мөнгө угаахтай тэмцэх" асуудлаар зохион байгуулж буй үндэсний семинарт оролцов. - 2024 оны 5-р сарын 30-ны өдөр Улаанбаатар хотноо гибрид хэлбэрээр зохион байгуулагдах ИТС-ын Гаалийн дэд хорооны 6-р хуралдааны хэлэлцэх асуудлын төсөлд саналаа өгч, ИТС-ын Секретариатад хүргүүлэв. - Монгол-Солонгосын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах хэлэлцээтэй холбогдуулан ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн 11-р зүйлийн 17-д заасан "дамжуулан өнгөрүүлэх асуудлыг хариуцсан үндэсний зохицуулагч"-ийн асуудлыг судлав.	
5	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэл эр	-	Нэгжийн чиг үүргийн хүрээнд "Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хяналтшинжилгээ хийх, үр дүнг үнэлэх аргачлал"-д заасан бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж, тайлагнасан байна.	"Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө", "Алсын хараа 2050" хөтөлбөрийн хүрээнд тус нэгжийн үйл ажиллагаанд хамаарах тайлан мэдээ байхгүй болно.	01.01-06.05
7	Нэгжийн эрсдэлийн Үйл ажиллагаа удирдлагыг хэрэгжүүлсэн байдал			Нэгжийн үйл ажиллагаанд эрсдэл тооцож ажилласан. Өмнөх онд тайлагнаж байгаагүй.	Нэгжийн гүйцэтгэлийг давхардалгүй, орхигдуулахгүй, үр дүнтэй зохион байгуулахад учирч болзошгүй эрсдэлийг таньж, тогтоон түүнийг бууруулахад тус нэгж анхаарал хандуулан ажилласан. Одоогийн байлаар орон тоо дутуу ажиллаж байгаа нь албан хаагч нарт ачаалал ирснээр ажлаас халшрах эмгэг ихэссэн. Түүнчлэн гадаад хамтын ажиллагааны хэлтэс нь ихэнх тохиолдолд европын цагаар буюу гадаад орны гаалийн байгууллагатай идэвхитэй холбоо барихын тулд ажлын бус цагаар ажилдаг, Түүнчлэн гадаадын зочид төлөөлөгчдийг шөнөөр тосох хүргэж	

					өгөх зэрэг нойргүй ажилласны дараа цаг бүртгүүлэх төхөөрөмжид бүртгүүлэх нь хүндрэл учруулдаг. Иймд албан хаагч нарын Ажил-Амьдралын тэнцвэрийг хангахын тулд ажил үүргийн хуваарийг уян хатан байдлаар өөрчлөх, илүү цагаар ажилласан цагийг ажлын өдөр нөхөн өгөх, эсхүл илүү цагийн мөнгийг нь олгуулах судалгаа хийж ажиллаж байна.	
8	Цаг үеийн асуудлаар удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх			Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг тухай бүр ханган ажиллаж, тайлагнана.	Удирдлагаас өгсөн 5 үүрэг даалгаврыг цаг тухайд нь 100% биелүүлэн ажилласан. Үүнд: - ГЕГ-ын даргын гадаад уулзалт, ажлын тайланг Сангийн Яам болон Гадаад Харилцааны Яаманд албан бичгээр хүргүүлсэн. - Дэлхийн Гаалийн Байгууллагын Ази, Номхон далайн бүс нутгийн Гаалийн дарга нарын 25 дугаар дээд хэмжээний уулзалт Австрали Улсын Сидней хотод 2024 оны 04 дүгээр сарын 14-18-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Ази, Номхон Далайн бүсийн 35 орны Гаалийн байгууллага (биетээр 32, цахим 3), Дэлхийн Гаалийн Байгууллагын Ерөнхий Нарийн Бичгийн Даргын Газар, Ази, Номхон Далайн Бүс Нутгийн Чадавхыг бэхжүүлэх төв, Бүс нутгийн Зөрчлийн мэдээлэл солилцсон ажлын хүрээнд холбогдох мэдээллийг Гаалийн байгууллагын Захиргаа, Дотоод Ажлын систем программд дэлгэрэнгүй тайлан, холбогдох мэдээллийг Гадаад арга хэмжээ талбарт байршуулж, гаалийн албан хаагчдын мэргэшлийн мэдлэгийг дээшлүүлж, үйл ажиллагаандаа ашиглаж байна. - Гаалийн ерөнхий газрын даргын 2016 оны А/69 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Гаалийн улсын байцаагчийн үйлчилгээний стандарт", 2021 оны А/251 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Гаалийн улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдгийг хэрэглэх журам"-ыг нийт албан хаагчиддаа танилцуулсан. ЗУГ-т 2024 оны 03-р сарын 13-ны өдөр 46 тоот дотоод зурвасаар хариу хүргүүлсэн. - Гаалийн ерөнхий газрын даргын 2021 оны А/251 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Гаалийн улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдэг хэрэглэх журам"-ын хэрэгжилтийг хангаж, журмын дагуу өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан. - ДГБ-ын Зөвлөлийн хуралдаан, Хороодын уулзалт, Ази, Номхон Далайн бүс нутгийн Дарга, Холбоо баригч нарын төлөвлөсөн уулзалтуудын төсвийг урдчилан тооцож жилийн эхэнд батлуулсан ба Монгол Улсын Гаалийн байгууллагын идэвх, оролцоог шинэ шатанд гаргах зорилгоор төлөвлөгдөөгүй зарим хурал, уулзалтад оролцох зардлын төсөвийг ГЕГ-ын даргаар батлуулж ажиллаж байна. ДГБ-ын чуулган энэ жилийн УИХ-ын сонгуультай давхцаж байгаа тул цахимаар оролцохоор шийдвэрлэгдсэн.	

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн дууссан хугацаа	Би
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)			
	1	2	3	4	5	6		
1	Гаалийн хөгжлийн чиг хандлагаас суралцах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр,	-	Гадаад хэл дээрх мэдээллийн эх сурвалжийг харьцуулан судлана.	Гаалийн хөгжлийн чиг хандлагаас суралцаж, дэлхий нийттэй хөл нийлүүлэн алхахын тулд ДГБ-ын вебсайт https://www.wcoomd.org/ болон фэйсбүүк пэйж хуудсаар тогтмол зочилж сүүлийн үеийн мэдээ, мэдээлэлтэй байнга танилцаж өдөр тутмын үйл ажиллагаа, орчуулгадаа ашиглаж байна.	01.01-06.05		
2	Богино хугацааны мэргэшлийн мэдлэг дээшлүүлэх сургалтад хамрагдсан байна	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Гаалийн байгууллагын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг болж ажилласан байна.	1. ДГБ-ын Гарал үүслийн үндэсний семинар 2. ОУВС-ийн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний семинар 3. WCO-Click Gender equality and inclusion in Customs WCO-Click Gender equality in Customs онлайн сургалтуудад онлайн болон биет хэлбэрээр тайлант хугацаанд хамрагдаж, гэрчилгээ авсан.	01.01-06.05		

ТАЙЛАН ГАРГАСАН:

ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТСИЙН
ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ

/Ө.НАМУУНБАЙГАЛ/

2024 ОНЫ 06 ДУГААР САРЫН 10-НЫ

ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ ӨСӨХБАЯР ОВОГТОЙ НАМУУНБАЙГАЛЫН
2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ
ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн Ерөнхий Газар

Нэгжийн нэр: Гадаад хамтын ажиллагааны хэлтэс

1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. “Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах” зорилтыг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Олон улсад гаалийн чиглэлээр хэрэглэж буй баримт бичгийг судалж, боловсруулсан байдал	50	10	60	
2	Хамтын ажиллагааны арга хэмжээг зохион байгуулсан байдал, гэрээ, хэлцэл, төсөл хөтөлбөрийн хэрэгжилт	50	10	60	
Зорилт 4. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх” зорилтыг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
3.	Албан хаагчдыг гадаад болон гадаадын экспертүүдийн сургалтад хамруулсан байдал, үр дүнг тооцох ажлыг зохион байгуулсан байдал	50	10	60	
4.	Монголын гаалийн байгууллагын үйл ажиллагааг гадаад орнуудад сурталчилах, холбоо баригчийн үүрэг гүйцэтгэх ажлыг зохион байгуулсан байдал	60	10	70	
5.	Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гадаад бичиг баримт орчуулж, гадаад хурал, арга хэмжээнд албан ёсны орчуулга хийх ажлыг зохион байгуулсан байдал	60	10	70	

6.	ДГБ бусад олон улсын байгуулагтай хамран ажиллаж, гаалийн байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд олон улсын тэргүүн туршлага, арга хэрэгслийг судалж санал, зөвлөмж боловсруулах, үйл ажилаагаандаа нэвтрүүлэх ажлыг зохион байгуулсан байдал	55	10	65	
7.	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	60	10	70	
8.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт	60	10	70	
9.	Нэгжийн эрсдэлийн Үйл ажиллагаа удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	60	10	70	
10.	Үүрэг даалгаврын биелэлт	60	10	70	
Зорилт 3. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах” зорилтын хүрээнд					
11.	ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлтийг хангах	45	10	55	
12.	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	60	10	70	
Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт					
13.	Цаг үеийн асуудлаар удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх	60	10	70	
Дундаж оноо:				66.1	

2. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийг хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Мэргэжлийн англи хэлний мэдлэгээ бие дааж түвшин ахиулах	100	15	
Дундаж оноо:			15	

3. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (НЭГЖИЙН ДАРГЫН ҮНЭЛГЭЭ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	
2.	Асуудал шийдвэрлэх	6	
3.	Хариуцлагатай байдал	6	
4.	Дүн шинжилгээ хийх	6	
5.	Ажлын цаг ашиглалт	7	
Дундаж оноо:		6,4	

4. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (ХАМТ ОЛНЫ ҮНЭЛГЭЭ)

Д/д	Хандлага, ёс зүй, ур чадвар	Хамт олны үнэлгээ (0-8)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	7
3.	Харилцаа	7
Дундаж оноо: 7		

5. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ


Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)	66,1
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	15
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	6,4

4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	7,3
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
Нийт оноо =94,8 (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ))- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		94,8

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга:

Гадаад хамтын ажиллагааны дарга



(Ө.Цолмон)


2024.06.10. (огноо)

**Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:**

Төрийн жинхэнэ албан хаагч:

Төрийн жинхэнэ албан хаагч:

Гаалийн улсын байцаагч




(Ө.Намуунбайгал)

2024.06.10. (огноо)

Үнэлгээг хянасан :

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч



(Г.Энхтайван)

2024.07.26. (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Хүний нөөцийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч




(Ж.Баясгалан)

..... (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:

Төсвийн шууд захирагч:

Гаалийн ерөнхий газрын дарга



(Р.Отгонжаргал)

..... (огноо)